



лд

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар №113

Шивээговь сум

Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн
тооллогын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Геодези, зураг зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын нутаг дэвсгэрт байрлах геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

Т.Өлзийбуд

(Газрын даамал)

2. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллогын ажлын удирдамжийг 1 дүгээр, маршрутын зургийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Цэг тэмдэгтийн тооллогын ажлыг удирдамжийн дагуу чанартай, хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (С.Отгонбаатар)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.



Сумын Засаг даргын 2023 оны
08 сарын 03 өдрийн тоот
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ГЕОДЕЗИЙН ХАТУУ ЦЭГ ТЭМДЭГТИЙН
ТООЛЛОГО, БҮРТГЭЛ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Газрын тухай хууль, Геодези зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийг бус нутагтаа хэрэгжүүлэх, геодезийн цэг тэмдэгтийн тооллогыг жил бүр хийх, хадгалалт, хамгаалалт болон орчны нөлөөлөлд өртсөн байдлын талаар арга хэмжээ авч ажиллах, мөн цэг тэмдэгтийг сэргээн засварлаж хэмжилт зураглалын ажлыг хийж гүйцэтгэх нөхцөлийг алдагдуулахгүй байхад энэхүү ажлын гол зорилго оршино.

Хоёр. Зорилт

- Цэг тэмдэгтийн хувийн хэргийн цэгцлэлт, бүрэн бүтэн байдлыг хангаж судалгаа бүртгэлийг урьдчилан бэлдэж, маршрутыг хавсаргасан байна.
- Бүх цэг тэмдэгтийг бүртгэл судалгаа, координатын дагуу газар дээр нь үзэж, тоолж, зураг дарж харьцуулан баримтжуулна
- Цэг бүр дээр тайлбар, тодруулгыг тэмдэглэсэн байна. Тухайлбал: устсан, гэмтсэн, нүүлгэн шилжүүлсэн гэх мэтээр;
- Урьд онуудад шинээр суулгасан цэгүүдийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалтыг шалгах, давхардал бий эсэхийг тодруулах /өөр нэршилээр бүртгэгдсэн эсэх/

Гурав. Ажиллах бүрэлдхүүн

Газрын даамал, багийн Засаг дарга нар тухайн сумандаа тооллогын ажлыг чанартай, бодитой, үр дүнтэй зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд аймгийн Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн арга зүйн зөвлөгөө чиглэл өгч хамтран ажиллана.

Дөрөв. Тоолох, бүртгэх цэг тэмдэгтүүд

- ✓ Нийт 18 цэг

Тав. Хугацаа

- ✓ 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 08 сарын 25-ний өдрийн хооронд

Зургаа. Явах чиглэл, маршрут

- ✓ Шивээговь суманд 250 км.

Сумын Засаг даргын 2023 оны
08 сарын 23 өдрийн тоот
захирамжийн 2 дугаар хавсралт

25

МАРШРУТ

